**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/001/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| | Дарга,Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа |
| | Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг |
| Цахим хуудас: www.audit.mn | Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn |
| Алтай хот | Ахлах аудитор: Д.Цэрэнханд |
| 2025 он | Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.05.25 № 132

танай ______________ -ны № ______________ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.ЗОЛЖАРГАЛ
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хөрөнгийн орлого 27,760.1 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 405.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан,
- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 1,990,003.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

8225020368

"Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 2 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын Орон нутгийн төсвийн орлогыг 14,393,394.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 14,987,331.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 593,937.2 мянган төгрөгөөр буюу 104.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд сум 4,610,885.0 мянган төгрөгийн орлогыг аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 1,191,182.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 206 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 92.8 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 5,617,184.9 | 4,578,059.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 740,523.2 | 1,305,393.4 |
| 33 | АВЛАГА | 1,226,235.1 | 1,296,759.6 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 0.0 | 1,864.2 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 274,083.4 | 374,551.4 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 21,817.0 | 44,596.0 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 3,354,526.2 | 1,554,895.3 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 11,570,670.4 | 11,132,550.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 11,570,670.4 | 11,132,550.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 11,210,924.4 | 10,809,464.6 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 359,746.0 | 323,085.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **17,187,855.3** | **15,710,610.3** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 342,596.3 | 299,850.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 342,596.3 | 299,850.5 |
| 41300 | Өглөг | 342,596.3 | 299,850.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 16,845,259.0 | 15,410,759.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 16,845,259.0 | 15,410,759.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 5,003,083.5 | 5,003,083.5 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 9,580,490.4 | 8,331,284.4 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,261,685.1 | 2,076,391.9 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **17,187,855.3** | **15,710,610.3** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **27,222,289.8** | **20,357,045.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 7,537,589.5 | 14,635,633.4 |
| 110 | Орлогын албан татвар | 6,776,157.9 | 13,192,335.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 7,153,023.8 | 13,735,270.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (376,865.9) | (542,934.5) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 232,495.5 | 296,808.9 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 528,936.1 | 1,146,488.8 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,145,534.5 | 1,812,025.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,145,534.5 | 1,812,025.7 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 12,539,165.9 | 3,909,386.3 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 21,188,248.5 | 17,455,802.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 21,188,248.5 | 17,455,802.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,997,741.6 | 12,685,073.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,275,536.1 | 3,702,937.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 369,919.8 | 600,479.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,360,423.8 | 3,936,331.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 407,901.8 | 355,271.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 350,063.6 | 272,738.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 888,783.7 | 430,788.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 20,883.9 | 35,461.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 324,351.2 | 534,065.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,999,877.7 | 2,816,998.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,190,506.9 | 4,770,728.9 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 6,034,041.3 | 2,901,243.4 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **907,718.2** | **4,399,618.2** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **5,126,323.1** | **(1,498,374.8)** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** | **Нийт цэвэр хөрөнгө/өмч** |
|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 15,308,126.1 | 15,308,126.1 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (1,524,970.9) | (1,524,970.9) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,783,155.2 | 13,783,155.2 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (1,009.3) | (1,009.3) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (2,063,210.0) | (2,063,210.0) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 5,126,323.1 | 5,126,323.1 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 16,845,259.0 | 16,845,259.0 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 16,845,259.0 | 16,845,259.0 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 249,168.8 | 249,168.8 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 17,094,427.8 | 17,094,427.8 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (185,293.2) | (185,293.2) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (1,498,374.8) | (1,498,374.8) |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 15,410,759.8 | 15,410,759.8 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

*2043 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **22,402,358.0** | **20,261,575.3** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 7,537,589.5 | 14,636,547.6 |
| 110 | Орлогын албан татвар | 6,776,154.9 | 13,192,335.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 7,153,020.8 | 13,735,270.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (376,865.9) | (542,934.5) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 232,495.5 | 297,723.1 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 528,939.1 | 1,146,488.8 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 334,942.7 | 362,299.3 |
| 1181 | Газрын төлбөр | 191,311.3 | 780,986.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 2,685.1 | 3,203.4 |
| 1183 | Бусад татвар | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,343,500.2 | 699,894.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,343,500.2 | 699,894.9 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 121 | Хөрөнгийн орлого | - | - |
| 122 | Тусламжийн орлого | - | - |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 12,521,268.3 | 4,925,132.8 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **17,984,544.0** | **16,405,436.2** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 17,984,544.0 | 16,405,436.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,871,826.1 | 10,627,166.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,515,871.1 | 2,777,203.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 319,454.2 | 512,013.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 220,070.0 | 3,982,873.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 301,528.1 | 289,941.8 |
| 2105 | Нормативд зардал | 125.0 | 506.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 85,130.7 | 411,432.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,863.9 | 31,161.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,071,847.6 | 572,253.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,339,935.5 | 2,049,781.6 |
| 211 | ХҮҮ | - | - |
| 212 | ТАТААС | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,112,717.8 | 5,778,269.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 4,417,814.0 | 3,856,139.1 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 4,195,516.1 | 3,182,705.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,195,516.1 | 3,182,705.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,195,516.1 | 3,182,705.4 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | - | - |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (4,195,516.1) | (3,182,705.4) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (200,000.0) | (101,847.9) |
| 14 | Бусад эх үүсвэр | - | - |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 200,000.0 | 101,847.9 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | - | - |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | - | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 22,298.0 | 571,585.9 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 718,225.2 | 740,523.2 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 740,523.2 | 1,305,393.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,933,978,000.0** | **12,385,795,088.6** | **548,182,911.4** | **95.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,386,509,800.0** | **9,261,379,462.1** | **125,130,337.9** | **98.7** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **9,268,097,800.0** | **9,144,148,590.1** | **123,949,209.9** | **98.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,770,740,000.0** | **1,708,791,615.4** | **61,948,384.6** | **96.5** |
| 210101 | Үндсэн цалин | 937,740,000.0 | 1,023,019,778.2 | (85,279,778.2) | 109.1 |
| 210102 | Нэмэгдэл | 833,000,000.0 | 443,091,231.7 | 389,908,768.3 | 53.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 96,108,337.5 | (96,108,337.5) | #DIV/0! |
| 210104 | Урамшуулал | - | 146,572,268.0 | (146,572,268.0) | #DIV/0! |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **222,250,000.0** | **186,347,188.5** | **35,902,811.5** | **83.8** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 175,450,000.0 | 140,759,691.7 | 34,690,308.3 | 80.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,700,000.0 | 12,585,824.2 | (885,824.2) | 107.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,850,000.0 | 4,692,612.1 | 1,157,387.9 | 80.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,850,000.0 | 4,942,612.1 | 907,387.9 | 84.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,400,000.0 | 23,366,448.4 | 33,551.6 | 99.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,857,177,800.0** | **3,839,902,315.6** | **17,275,484.4** | **99.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 213,500,300.0 | 206,180,408.3 | 7,319,891.7 | 96.6 |
| 210302 | Түлш, халаалт | 3,068,680,200.0 | 3,068,669,812.2 | 10,387.8 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 574,997,300.0 | 565,052,095.2 | 9,945,204.9 | 98.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **78,975,800.0** | **77,831,264.0** | **1,144,536.0** | **98.6** |
| 210401 | Бичиг хэрэг | 16,555,800.0 | 16,266,340.0 | 289,460.0 | 98.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,700,000.0 | 46,839,100.0 | 2,860,900.0 | 94.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,620,000.0 | 9,014,016.0 | (394,016.0) | 104.6 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.0 | - | 500,000.0 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.0 | 720,000.0 | (620,000.0) | 720.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,500,000.0 | 4,991,808.0 | (1,491,808.0) | 142.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **557,765,800.0** | **542,381,183.5** | **15,384,616.5** | **97.2** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 105,600,000.0 | 105,435,300.0 | 164,700.0 | 99.8 |
| 210602 | Тавилга | 27,900,000.0 | 27,882,400.0 | 17,600.0 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 424,265,800.0 | 409,063,483.5 | 15,202,316.5 | 96.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **33,687,200.0** | **31,161,150.0** | 2,526,050.0 | 92.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 33,687,200.0 | 31,161,150.0 | 2,526,050.0 | 92.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **326,901,200.0** | **338,070,521.0** | (11,169,321.0) | 103.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 323,826,200.0 | 335,192,952.0 | (11,366,752.0) | 103.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.0 | 64,500.0 | 35,500.0 | 64.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 415,000.0 | 414,232.0 | 768.0 | 99.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,000.0 | 22,000.0 | 38,000.0 | 36.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000.0 | 1,972,900.0 | 27,100.0 | 98.6 |
| 210807 | Газрын төлбөр | 500,000.0 | 403,937.0 | 96,063.0 | 80.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,420,600,000.0** | **2,419,663,352.1** | 936,647.9 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,390,600,000.0 | 2,389,758,252.1 | 841,747.9 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,000,000.0 | 29,905,100.0 | 94,900.0 | 99.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **118,412,000.0** | **117,230,872.0** | 1,181,128.0 | 99.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **118,412,000.0** | **117,230,872.0** | 1,181,128.0 | 99.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 79,942,000.0 | 79,194,372.0 | 747,628.0 | 99.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 38,470,000.0 | 38,036,500.0 | 433,500.0 | 98.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,313,468,200.0** | **3,022,567,767.5** | 290,900,432.5 | 91.2 |
| 223001 | Бусад хөрөнгө | 3,313,468,200.0 | 3,022,567,767.5 | 290,900,432.5 | 91.2 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **234,000,000.0** | **101,847,859.0** | 132,152,141.0 | 43.5 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 234,000,000.0 | 101,847,859.0 | 132,152,141.0 | 43.5 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,933,978,000.0** | **12,669,286,326.8** | 264,691,673.2 | 98.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **12,624,810,800.0** | **12,386,108,484.1** | 238,702,315.9 | 98.1 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 10,162,509,800.0 | 10,032,148,728.1 | 130,361,071.9 | 98.7 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 2,462,301,000.0 | 2,353,959,756.0 | 108,341,244.0 | 95.6 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **309,167,200.0** | **283,177,842.7** | 25,989,357.3 | 91.6 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.0 | 277,080,562.7 | (276,080,562.7) | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 6,097,280.0 | (6,097,280.0) | |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 308,167,200.0 | - | 308,167,200.0 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 252,661,012.7 | (252,661,012.7) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 536,152,251.0 | (536,152,251.0) | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **195,506,637.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **195,506,637.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **176,091,172.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,000,000.00** |

| | | |
|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **166,091,172.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 166,091,172.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,415,465.00** |
| **2133** | ***Олгосон санхүүжилт, шилжүүлэг*** | **19,415,465.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 19,415,465.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **195,506,637.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **195,506,637.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 15,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 163,541,137.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,965,500.00 |

## 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар нийт 10,368.5 сая төгрөгийн 1 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.
Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийн орлого, өглөг авлаг, зардлын 10,368.5 сая төгрөгийн устгах бичилтийг хийгээгүйгээс тайлан буруу илэрхийлэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 28.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин бага бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 1,975.6 сая байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 28.1 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 3.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 23 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал, 3 тусгай сан, 2 ААТҮГ, 1 төрийн сангийн санхүүгийн тайлан нэгтгэснээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 17 байгууллага, 3 тусгай сан түүвэрт хамруулсан.

Аудитаар Есөнбулаг сумын ЗДТГ, ИТХ, Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төв, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.1.2 Түүвэрт хамрагдсан Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 595.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 9.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 707.7 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

### 3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 500.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 989.9 сая төгрөгийн 24 зөрчил илрүүлж, 40.3 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 947.5 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 16 албан шаардлага, 2.1 сая төгрөгийн 1 заалт зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар өглөг, орлоготой холбоотой 10,368.5 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.
Аудитаар нийт 28.2 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс 28.2 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

### 3.3 Албан шаардлага

1. Хөрөнгийн орлого 27.8 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 0.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,175.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 1,185.8 сая төгрөгийн алдааг залруулсан ба 59.7 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 1,915.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 29 албан шаардлага, 14.4 сая төгрөгийн 4 заалт зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Есөнбулаг сумын Засаг дарга | 1 | 10,368,510.9 | - | - | 1 | 10,368,510.9 | 1 | **10,368,510.9** | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар | 4 | 490,379.9 | - | - | 4 | 490,379.9 | 4 | 490,379.9 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 5 | 10,196.9 | - | - | 5 | 10,196.9 | 5 | 10,196.9 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сан | 6 | 699,135.0 | - | - | 6 | 699,135.0 | 6 | 699,135.0 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сан | 3 | 595,430.6 | - | - | 3 | 595,430.6 | 3 | 595,430.6 | - | - | - | - |
| Алтай хотын тохижилт үйлчилгээний газар | 1 | 52,400.0 | - | - | 1 | 52,400.0 | 1 | 52,400.0 | - | - | - | - |
| Энх-Алтай. Өрхийн эмнэлэг | - | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| Жаргалан-Алтай Өрхийн эмнэлэг | 1 | - | - | - | 1 | - | 1 | | - | - | - | - |
| Марал-Алтай. Өрхийн эмнэлэг | 1 | 37,477.2 | - | - | 1 | 37,477.2 | 1 | 37,477.2 | - | - | - | - |
| **Дүн** | **22** | **12,253,530.5** | - | - | **22** | **12,253,530.5** | **22** | **12,253,530.5** | - | - | - | - |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Есөнбулаг сумын Засаг дарга | 1 | - | 1 | - | - | - | 1 | 28,165.7 | | | 1 | 28,165.7 | | | | | | |
| Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | 1 | - | - | - | 12 | 791,374.0 | 4 | 10,758.1 | 7 | 778,468.7 | 1 | 2,147.2 | | | | |
| Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | 1 | - | - | - | 9 | 67,270.5 | 2 | 3,543.7 | 7 | 63,726.8 | - | - | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сан | 1 | - | - | - | - | 1 | 5 | 707,754.4 | - | - | 5 | 707,754.4 | - | - | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 6,000.0 | 1 | 6,000.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Есөнбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 3,605.4 | 1 | 3,605.4 | - | - | - | - | - | - | - | - |
| Алтай хотын тохижилт үйлчилгээний газар | 1 | | 1 | | | | 6 | 187,728.6 | 1 | 314.0 | 5 | 187,414.6 | - | - | - | - | - | - |
| Энх-Алтай. Өрхийн эмнэлэг | 1 | - | - | - | - | 1 | 1 | 934.5 | - | - | - | - | 1 | 934.5 | - | - | - | - |
| Жаргалан-Алтай Өрхийн эмнэлэг | 1 | - | - | - | - | 1 | 1 | 822.0 | - | - | - | - | 1 | 822.0 | - | - | - | - |
| Марал-Алтай. Өрхийн эмнэлэг | 1 | | 1 | - | - | | 7 | 93,213.1 | 3 | 9,506.8 | 3 | 73,209.3 | 1 | 10,497.0 | - | - | - | - |
| **Дүн** | **10** | **-** | **5** | **-** | **-** | **5** | **44** | **1,886,868.2** | **12** | **33,728.0** | **28** | **1,838,739.5** | **4** | **14,400.7** | **-** | **-** | **-** | **-** |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**(мянган төгрөг)**

| **Байгууллагын нэр** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар | 3 | 131,301.2 | 1 | 25,979.8 | 2 | 105,321.4 | - | - |
| **Дүн** | **3** | **131,301.2** | **1** | **25,979.8** | **2** | **105,321.4** | - | - |

## 5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| **1** | **ТШЗ** | **5** | **1** | **4** | | | **1** | | |
| **2** | **ТТЗ** | **1** | **1** | | | | **1** | | |
| | **НИЙТ** | | **2** | | | | **2** | | |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР